

Сургуулийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

NSW мужийн бүх улсын сургуулиудын дэргэдэх зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан сурагчид сэтгэл зүйн туслалцаа авах боломжтой.

Сургуулийн зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд сургуулийн зөвлөх, болон сэтгэл зүйч нар бэлтгэл ангиас 12-р анги хүртэлх бүх насны сурагчдад зөвлөгөө өгөх, сэтгэлзүйн үнэлгээ хийх, хөндлөнгөөс арга хэмжээ авах үйлчилгээг үзүүлдэг. Тэд сурагчийн гэр бүл, сургуулийн ажилтнууд болон бусад мэргэжилтнүүдтэй хамтран сурагчийн суралцах байдал, сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлын хэрэгцээг хангах мөн сурагчдад аюулгүй, эрүүл, дэмжин тусалдаг сургалтын орчныг бүрдүүлэхийг зорьж ажилладаг.

Сургуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг ажилтнууд нь бүгд бакалавраас дээш түвшинд сэтгэл судлалын чиглэлээр мэргэшсэн бөгөөд тэд хүүхэд, залуучуудыг сурлага, нийгэм, зан үйл, сэтгэл хөдлөлийн хувьд амжилтанд хүрэхэд нь туслах зорилгоор сэтгэцийн эрүүл мэнд, суралцах байдал, зан үйлийн чиглэлээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг.

Сургуулийн зөвлөх эсвэл сургуулийн сэтгэл зүйч дараах үйлчилгээг үзүүлэх боломжтой:

- сурагчдад зөвлөгөө өгөх
- сурагчийн суралцах байдал, сэтгэцийн эрүүл мэндийн хэрэгцээнд үнэлгээ хийх
- багш, мэргэжлийн ажилтнуудтай хамтран ажиллах
- гэр бүлүүдэд хүүхдийнхээ сурах байдал болон сэтгэцийн эрүүл мэндийн хэрэгцээг ойлгож, удирдахад нь туслах
- сурагчдад зохион байгуулалттай, цогц дэмжлэг үзүүлэхийн тулд гадны бусад агентлаг болон сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай харилцан хамтран ажиллах.

Сурагч, эцэг эх, асран хамгаалагч, багш нартай хамтран ажиллах явцад сургуулийн зөвлөх ажилтнууд нь тэдэнд өөрсдийн хэрхэн яаж ажилладаг талаар тайлбарлах, тэднийг анхааралтай сонсох, тэдэнд ямар сонголтууд байгааг тайлбарлах, мөн мэдээлэл дээр үндэслэсэн зөв шийдвэр гаргах зэрэгт тусална.

Мэдээллийн нууцлал

Сургуулийн зөвлөх үйлчилгээний ажилтнууд сайн дурын үндсэн дээр сурагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэн ажилладаг. Хуульд заагаагүй л бол аюулгүй байдал, эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулахаас бусад тохиолдолд нууц мэдээллийг сурагч, эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр бусадтай хуваалцахгүй.

Лавлагаа

Сургуулийн зөвлөгөө өгөх дэмжлэгийн тэргүүлэх чиглэлийг сургуулийн боловсрол, сайн сайхан байдлын багуудтай зөвлөлдсөний үндсэн дээр тодорхойлдог. Хүүхдийнхээ сурч боловсрох, сэтгэцийн эрүүл мэнд болон/эсвэл сайн сайхан байдалд санаа зовж буй эцэг эх, асран хамгаалагчид сургуультай холбогдож цаг товлох боломжтой. Сурагч өөрөө хандахаас гадна эцэг эх, багш нараас хүсч цаг товлох боломжтой.

Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрэв та нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл сургууль руу залгана уу. Сургуультай харилцахад тань орчуулагч хэрэгтэй байгаа бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаараар холбогдож өөрийн хэлээр орчуулагч авна уу.

Операторт залгахыг хүсч буй утасны дугаараа хэлвэл оператор шугаманд орчуулагчийг оруулж ирэн танд туслах болно. Энэхүү үйлчилгээ үнэ төлбөргүй.